

**НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ**

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	<b>Нэр</b> Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Бүргэд овогт Цээхээгийн Адъяахишиг
2	<b>Хүсэлт гаргагчийн хаяг</b> Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	<b>Төрсөн огноо</b> Төрсөн газар	
4	<b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд “Хөдөлмөрлөх эрхтэй холбоотой гомдлууд, тэдгээрт хийсэн шинжилгээ” сэдвээр хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. <i>Суралцсан хугацаа</i> 2013.09.01-2016.06.02  Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи, Төрийн алба, удирдлагын сургуулийг Төрийн удирдлагаар мэргэшсэн. <i>Суралцсан хугацаа</i> 2009.09.01-2011.06.06  Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургуулийг Хууль зүйн бакалаврын зэрэгтэй төгссөн <i>Суралцсан хугацаа</i> 1993.09.01-1998.06.12
5	<b>Ажил эрхлэлт</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	<b>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс</b> Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар <a href="mailto:info@nhrcm.gov.mn">info@nhrcm.gov.mn</a> 51-260284 51-262915  <b>Улсын Их Хурлын Тамгын газар</b> Монгол Улс 14201, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон 976-51-267016 <a href="http://www.parliament.mn">www.parliament.mn</a> <a href="mailto:secretariat@parliament.mn">secretariat@parliament.mn</a>

		<p><b>Талх чихэр ХХК</b> Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 29 дүгээр хороо, Талх чихэр ХХК-ны байр <a href="mailto:info@talkh-chikher.mn">info@talkh-chikher.mn</a></p> <p><b>Хууль зүй, дотоод хэргийн яам</b> Засгийн газрын V байр, Худалдааны гудамж 6/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот <a href="http://www.mojha.gov.mn">www.mojha.gov.mn</a> <a href="mailto:info@mojha.gov.mn">info@mojha.gov.mn</a> 976-51-267533</p>
6	<p><b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.</p>	Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн
7	<p><b>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил</b> Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ. -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• <i>Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:</i> <b>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс</b> - Захиргаа, удирдлагын хэлтэс Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч <i>Ажилласан хугацаа: 2020.01.23-аас</i> - Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс <i>Ажилласан хугацаа</i> Ахлах референт 2018.01.22-2020.01.22 Хэлтсийн дарга 2017.04.12- 2018.01.21 Ахлах референт 2009.01.19-2018.01.21 Референт 2008.06.06-2009.01.18</li> </ul> <p><i>Хавсран гүйцэтгэж буй албан тушаал</i> “Хүний эрх” сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2008 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Тушаал № 26</p> <p>Хүний эрхийн Үндэсний Комиссын Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүн Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2014 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Тушаал № 05 Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Тушаал № А/3 Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны даргын 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Тушаал № А/05</p> <p><b>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс</b></p>

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар  
[info@nhrcm.gov.mn](mailto:info@nhrcm.gov.mn)  
51-260284  
51-262915

- *Ажлын байрны тодорхойлолт: (Ажлын байр тус бүрээр тодорхойлолтыг хавсаргав).*

**Улсын Их Хурлын Тамгын газар**

*Албан тушаалын нэр*

- Улсын Их Хурлын гишүүний туслах

*Ажилласан хугацаа 2000.07.26-2003.08.31*

*Ажлын байрны тодорхойлолт:*

- Гишүүний санаачилсан болон ахлан ажилласан хуулийн төсөл боловсруулахтай холбоотой судалгаа, мэдээллийг бэлтгэх, хууль тогтоомжийн төсөлд оруулах саналын томъёоллыг бэлтгэх,
- Гишүүний ахлан ажиллаж буй ажлын хэсгийн хуралдаан, хэлэлцэх асуудалтай холбоотой санал, дүгнэлт материалыг бэлтгэх, холбогдох байнгын хорооны ажилтнуудтай хамтран ажиллах
- Гишүүний сонгогдсон тойрог дахь бие төлөөлөгчтэй орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хамтран зохион байгуулах, үр дүн, тайлангийн төсөл боловсруулах
- Гишүүний хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хурал, уулзалт, арга хэмжээний үеэр хэлэх үг, илтгэлийн төсөл боловсруулах,
- Гишүүний байнгын хороо, ажлын хэсэг, чуулганы хуралдаанд оролцоход шаардлагатай хууль, тогтоомжийн төсөл, холбогдох материалыг бэлтгэх, төлөвлөх, зохион байгуулалтын ажлыг хариуцах,
- Гишүүнд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой хууль, тогтоомж, эрх зүйн зохицуулалтын асуудлыг судалж, санал бэлтгэн танилцуулах,
- Өдөр тутмын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллах зэрэг болно.

- *Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл:*

**Хууль зүйн яам** (тухайн үеийн нэршилээр)

*Албан тушаалын нэр:*

- Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

*Ажилласан хугацаа 1999.01.27-1999.08.24*

		<p><i>Албан тушаалын нэр</i>  - Хууль зүйн сайдын туслах  <i>Ажилласан хугацаа 1998.06.15-1999.01.19</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• <i>Ажлын байрны тодорхойлолт:</i></li> </ul> <p>А. Эрх зүйн сургалтын болон давтан сургалтын үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулахтай холбоотой дараах чиг үүргийг гүйцэтгэж байсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хууль зүйн дээд боловсрол олгох үйл ажиллагаатай холбогдсон бодлого боловсруулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний талаар санал бэлтгэх;</li> <li>2. Хууль зүйн сургалтын асуудлаар Хууль зүйн сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;</li> <li>3. Хуульч боловсон хүчний мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах, яамны аппаратын албан хаагчдыг гадаад, дотоод сургалтад хамруулах ажлыг зохицуулах;</li> <li>4. Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх;</li> </ol> <p>Б. Сайдын тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сайдын зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулах, хурлын протоколыг хөтлөн албажуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;</li> <li>2. Сайдаас Төрийн нарийн бичгийн дарга, бусад газар хэлтсийн дарга нарт өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээллийг бэлтгэх, шаардлагатай мэдээллээр хангах;</li> <li>3. Сайдын өдөр тутмын ажлын хуваарийг урьдчилан тохирч зохицуулж байх;</li> <li>4. Яамны ажилтнуудын гүйцэтгэх ажил үүргийн хуваарийн дагуу яамны үйл ажиллагаанд оролцох;</li> </ol>
8	<p><b>Ёс зүй</b>  Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.  -сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх;  -сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.</p>	<p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан тохиолдол байхгүй</p> <p>Ямар нэгэн улс төрийн албан тушаал, улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.</p>

<p>9</p>	<p><b>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар</b>  Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</li> </ul>	<p><b>Хууль, тогтоомж, дүрэм журмын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж санал өгсөн байдал</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны даргын 2013 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тушаал, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/1 тушаалаар хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж буй эсэхэд санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилаж байна. 2013 оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд УИХ-аар хэлэлцэгдэх хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоолоор батлагдах буй дүрэм, журмын төслүүдэд хүний эрхийн олон улсын гэрээ конвенц, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж буй эсэх асуудлаар санал хүргүүлснээс 39 хууль, тогтоомж, дүрэм журмын төсөлд санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан ба үүнээс 11 төсөлд бие даан ажиллаж, саналын томъёоллыг боловсруулсан болно.  <i>(Хууль, тогтоомж, дүрэм журмын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж санал өгсөн дэлгэрэнгүй бүртгэлийг хавсаргав)</i></li> <li>2. Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, Б.Саранчимэг, Ш.Раднаасэд, Ц.Даваасүрэн нарын өргөн мэдүүлсэн Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалтын тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Дэд ажлын хэсэг нь 2019 онд 3 удаа хуралдсан бөгөөд ажлын хэсгийн хуралдаанд тогтмол оролцож тээгч эхийн болон тээгч эхээс төрсөн хүүхдийн эрх, эрүүл мэндийн болон хувь хүний нууцын холбоотой асуудлыг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн тусгахад анхааран ажиллаж байна.  <i>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан Монгол улсын их хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны 11-р сарын 20-ны өдөр /мягмар гараг/-ийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.</i></li> <li>3. Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн асуудлыг 2018 оноос хариуцан ажиллаж байна. Ингэхдээ ХЭҮК-ын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн болон хүний эрхийн аливаа асуудлаар мэдээ, мэдээллийг боловсруулан цахим хуудас болон бусад хэлбэрээр энгийн ойлгомжтой байдлаар иргэдэд хүртээмжтэй хүргэх, бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн явуулж байна. Комиссын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг, Эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулж, үйл ажиллагааны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийн биелэлтийн тайлан, мэдээллийг боловсруулан тухай бүр нь Бүх нийтийн</li> </ol>
----------	---	--

		<p>эрх зүйн боловсролын Үндэсний зөвлөлд хүргүүлж ажиллалаа.  Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвтэй хамтран ажиллаж, Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа, бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, хүний эрхийн талаарх мэдээллийг хялбаршуулсан байдлаар боловсруулан И-хөтөч цахим хуудаст байрлуулах, иргэд олон нийтэд түгээх зэрэг ажлыг хийж байна.</p> <p>4. Монгол Улсын Засгийн газраас байгуулсан “Мөнгөн усны тухай” Минаматагийн конвенцоор хүлээсэн үүргийн дагуу “Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2017-2019 онд ажилласан. Тус ажлын хэсэгт ажиллах хугацаандаа ажлын хэсгийн хуралдаанд тогтмол, идэвхтэй оролцож, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтийг сайжруулах, гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас үүдэлтэй хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөлөл, түүнийг бууруулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн зөрчил, түүнээс урьдчилсан сэргийлэхтэй холбоотой саналуудыг гарган үндэсний хөтөлбөр болон төлөвлөгөөнд тусгахад зохих хувь нэмрээ оруулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 317 дугаар тогтоолоор “Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр”, 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхайн сайдын хамтарсан А/232, А/66 тоот тушаалаар “Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө” батлагдсан болно.  <i>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн тушаалыг хавсаргав.</i></p> <p>5. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/218 дугаар тушаалаар байгуулагдсан Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалттайгаар хэрэгжүүлэх салбар дундын байнгын ажлын хэсгийн Удирдлагын багийн гишүүнээр ажиллаж байна.</p> <p>Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг бусад салбар байгууллагуудаас хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулахад анхаарч ажилласан. Ингэхдээ Комиссоос хүүхдийн эрхийн чиглэлээр хийсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүнд илэрсэн хүүхдийн эрхийн зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замын талаар бусад салбарын бодлого, үйл ажиллагаанд тусгуулах талаар санал гаргах, Ажлын хэсгийн хуралдаанд Комиссоос хүүхдийн эрхийн асуудлаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл, танилцуулга хийх, тайлан, мэдээллийг цаг тухайд нь боловсруулан ажиллаж ирсэн.</p>
--	--	--

		<p>6. Глобаль сангийн санхүүжилттэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх Үндэсний Зохицуулах зөвлөлд төрийн байгууллагын төлөөллөөр буюу Хүний эрхийн Үндэсний Комиссыг төлөөлөн 2017 оны 2 дугаар сарын 03-наас хойш 2 дахь удаагаа гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тус Үндэсний зохицуулах зөвлөл нь Монгол Улсын Засгийн газар, Глобаль сантай ХДХВ/ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх асуудлаар байгуулсан гэрээ, /цаашид “гэрээний нөхцөл” гэх/ Глобаль сангийн зөвлөмжийн дагуу тус сангийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэх үндсэн хүлээн авагчийг сонгон шалгаруулах, үндэсний хэмжээнд төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах, батлагдсан санхүүжилтийн хэрэгжилтэнд ерөнхий хяналт тавих, оролцогч талуудын үйл ажиллагаа уялдуулах чиг үүрэгтэй ажилладаг. Тус зөвлөлд ажиллах хугацаандаа Хүний эрхийн Үндэсний Комиссын төлөөллийн хувьд дараах дараах ажлыг хийсэн болно. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>- ҮЗЗ-ийн хурлаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцож, хурлаар хэлэлцэж буй асуудлын хүрээнд хүний эрхийн асуудлаар санал гаргах, хурлын шийдвэрт тусгуулан ажиллаж, ҮЗЗ-ийн үйл ажиллагааг ҮЗЗ нь үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчилгүй явуулах, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хорооны даргын үүргийг гүйцэтгэж байна.</li> <li>- “ХДХВ/ДОХ болон сүрьеэ өвчинтэй тэмцэх глобаль сангийн монгол дахь үндэсний зохицуулах зөвлөлийн дүрэм”-ыг шинэчлэн боловсруулах ажилд идэвх санаачлагтай оролцож, 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн ҮЗЗ-ын 77 дахь хуралдаанаар дүрмийг хэлэлцүүлэн батлуулсан.</li> <li>- Монгол Улсын хууль, тогтоомж болон Глобаль сангийн үндсэн шаардлагын дагуу Монгол Улсад хэрэгжиж буй төслийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, үндсэн болон салбар хүлээн авагчийн төсөл хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд тулгарсан саад бэрхшээлийг цаг алдалгүй шийдвэрлэх үүднээс Увс, Говь-Алтай, Төв, Дундговь, Өмнөговь, Булган, Хөвсгөл аймгуудад хэрэгжиж буй Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн үйл ажиллагаатай танилцаж, төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцын талаар Үндэсний зохицуулах зөвлөлийн хуралд танилцуулан тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн Зөвлөмжийг Эрүүл мэндийн яам болон холбогдох аймгийн Засаг дарга нарт хүргүүлж ажилласан.</li> </ul> <p>Мөн Үндэсний зохицуулах зөвлөлийн гишүүнээр ажиллах хугацаандаа Глобаль Сангийн дэмжлэгтэй 8 орны түлхүүр хүн амд чиглэсэн ДОХ-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, төслийн санал боловсруулан хүргүүлж, санхүүжилт авсан.</p> <p>7. <i>“Цагдан хоригдож буй хүмүүсийн өмгөөлөгч авах, хэргийн талаар хангалттай хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт”-ийн судалгаа.</i></p> <p>Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2015 онд шүүхийн өмнөх шатанд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр татагдан цагдан хоригдож буй хүмүүсийн өмгөөлөгч авах, хэргийн талаар хангалттай хууль зүйн</p>
--	--	---

		<p>туслалцаа авах эрх зөрчигдөх явдал гарсаар байгаа талаарх иргэдийн гомдол, мэдээлэлд тулгуурлан “Цагдан хоригдож буй хүмүүсийн өмгөөлөгч авах, хэргийн талаар хангалттай хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт” судалгааны ажлыг хийсэн. Миний бие энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэх багт ажилласан бөгөөд судалгаанд ШШГЕГ-ын харъяа цагдан хорих байранд хоригдож буй 691 сэжигтэн, яллагдагч хамрагдсан юм. Судалгаагаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийг зөрчихгүй байх, хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдахгүй байх, гэм буруугүй хүний эрх, эрх чөлөөнд халдан баривчлах, цагдан хорихгүй байх, улмаар хилсээр ял шийтгэл хүлээлгэхгүй байх эрхийн хэрэгжилтийн байдлыг судлан цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, өмгөөлөгчийн оролцоо, эрх үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох дүгнэлт, саналыг гаргасан.</p> <p>Судалгааны үр дүнг нэгтгэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлд оруулж зохих шийдвэр гаргуулахаар Улсын Хуралд өргөн мэдүүлсэн.</p> <p>8. Хүний эрхийн чиглэлээр хийсэн бусад судалгаа</p> <p>Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтсийн ахлах референтийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Комиссын стратеги төлөвлөгөө болон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрхийн асуудлаар хийхээр төлөвлөсөн үйл ажиллагаанд байнга оролцож, 2016 оноос эхлэн хүүхдийн эрхийн асуудлаар хийсэн дараах томоохон судалгааны ажлуудыг хариуцан гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• “Казах, Тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал” судалгаа 2010 он,</li> <li>• “Нийгмийн халамжийн салбар дахь төрийн үйлчилгээ - Хүний эрх ба хүнд суртал” судалгаа. 2012 он,</li> <li>• “Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал” судалгаа. 2015 он,</li> <li>• “Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалагчдын эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа. 2015 он,</li> <li>• Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт. 2015-2016 он,</li> <li>• Хүүхдийн эрх ба хамгаалал/ Хүүхдийн эрхийн мэдлэг, хандлага, хэрэгжилт тодорхойлох судалгаа. 2017 он,</li> <li>• Хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт судалгаа. 2017 он.</li> </ul> <p>Тэрчлэн Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд нейборс олон улсын төрийн бус байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар, Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл зэрэг байгууллагуудтай хамтран хийсэн “Хүүхдийн эрх ба хамгаалал” мэдлэг, хандлага, хэрэглээг тодорхойлох судалгаа, “Хэлний цөөнх хүүхдийн</p>
--	--	---



		<p>сурч боловсрох эрх” судалгааны ажлуудад оролцож, судалгааны үр дүнд тулгуурлан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийн “Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал” бүлгийг бичиж боловсруулсан.</p> <p>Мөн Хүүхдийн эрх ба хамгаалал судалгааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комисс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гүүд нейборс олон улсын төрийн бус байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран 2019 оны 11-р сарын 29-ны өдөр “Хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах нь” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга болон Эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах саналуудыг бэлтгэн холбогдох ажлын хэсэгт нь хүргүүлсэн болно.</p> <p>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар, Комиссын гишүүн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл шаардлага, байгууллага, албан тушаалтан хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлдэг юм. Миний бие Комисст ажиллах хугацаандаа 28 удаагийн “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээнд оролцож Монгол Улсын 19 аймагт ажилласан.</p> <p>Энэхүү арга хэмжээний хүрээнд хүний эрхийн сургалт хийх, орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийх, хууль хяналтын болон зэвсэгт хүчний анги салбаруудын үйл ажиллагаанд хүний эрхийн хяналт шалгалт хийх, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх зэрэг чиг үүргүүдийг гүйцэтгэж ирсэн. Ингэхдээ “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээний үр дүнг нэгтгэн дүгнэж, аймгийн хэмжээнд хүний эрхийн нөхцөл байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх чиглээр аймгийн Засаг дарга нарт хандсан Комиссын гишүүний 6 зөвлөмжийн төслийн боловсруулсан. Мөн хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан Комиссын гишүүний зөвлөмж 1, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын даргад хандсан Комиссын гишүүний 1 шаардлагын төслийг боловсруулсан болно.</p> <p>9. Монгол Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтнаар 2000-2003 онд ажиллахдаа Улсын их хурлын гишүүн Ц.Оюунбаатарын ахлан ажиллаж байсан Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон Эрүүгийн хууль боловсруулах ажилд дэмжлэг тусалцаа үзүүлж, гишүүнээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу дэлхийн бусад улс орнуудын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл цуглуулах, бэлтгэх, харьцуулсан дүн шинжилгээ хийх, мөн Ц.Оюунбаатар гишүүний Иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар бичих ажилд дэмжлэг үзүүлж ажилласан.</p> <p>10.</p>
--	--	---

		<p>11. Хууль зүйн яаманд Эрх зүйн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллах хугацаандаа хууль зүйн их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, эрх зүйч мэргэжлийн боловсон хүчний эрэлт, хэрэгцээг судалж, судалгаанд үндэслэн жил бүрийн суралцагчдын тооны хязгаарыг тогтооходой холбоотой санал боловсруулах, яам, түүний харъяа агентлаг, байгууллагуудын албан хаагчдын боловсролын талаарх судалгаа мэдээллийг нэгтгэн, өндөр хөгжилтэй орны их, дээд сургуулийн магистрантур, докторантурт хамруулах талаар санал бэлтгэх, зохион байгуулах ажлыг гүйцэтгэж байсан бөгөөд 1999 онд Хууль зүйн яамны мэргэжилтэн Эрдэнэбулганыг АНУ-д, Отгончимэг, Дуламсүрэн нарын ХБНГУ-д магистрантурт суралцах асуудлыг Гэгээрлийн яаманд (тухайн үеийн нэршлээр) хүргүүлж шийдвэрлүүлж байсан.</p>
10	<p><b>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил</b>  Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:  -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;  -ажлын байрны тодорхойлолт;  -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;  -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</p>	<p><b>Хүний эрхийн Үндэсний Комисс</b>   <i>Албан тушаалын нэр</i>  <b>Захиргаа, удирдлагын хэлтэс</b>  Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч  <i>Ажилласан хугацаа:</i>  2020.01.23-аас өнөөг хүртэл  <b>Хүний эрхийн боловсролын хэлтэс</b>  Ахлах референт  <i>Ажилласан хугацаа:</i>  2018.01.22-2020.01.23  <b>Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтэс</b>  Хэлтсийн дарга  <b>Бодлогын дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтэс</b>  Сургалт, сурталчилгаа хариуцсан Ахлах референт  <b>Боловсрол, сургалт, сурталчилгааны багт</b>  Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан Ахлах референт, референт  <i>Ажилласан хугацаа:</i>  2008.06.06-2012.01.02   Ажлын байрны тодорхойлолтуудыг хавсаргав.</p>
11	<p><b>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал</b>  Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:  -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн</p>	<p><b>1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл</b>  Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11, 9 дүгээр зүйлийн 9.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу Комисс тухайн жилийн хүний эрхийн нөхцөл байдлыг тодорхойлж Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг боловсруулж эхний улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн барьдаг. Энэхүү илтгэлийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж дараах 9 илтгэлийн тодорхой бүлгийг боловсруулахад хувь нэмрээ оруулж ажилласан. Үүнд:</p>

<p>газар, хугацаа;          -үйл ажиллагааны гол агуулга;          -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;          -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;          -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;          -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. 2009 он, 2 дугаар бүлэг. <i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт</i></li> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл, 4 дүгээр бүлэг. <i>Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн нөхцөл байдал. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ ба хүний эрх</i></li> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл, 3 дугаар бүлэг. <i>Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрхийн нөхцөл байдал</i></li> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дахь илтгэл, 2 дугаар бүлэг. <i>Хүний эрхийг хамгаалагчийн эрх</i></li> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл, 1 дүгээр бүлэг. <i>Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал.</i></li> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл, 2 дугаар бүлэг. <i>Нийслэлийн хот төлөвлөлттэй холбоотой хүний эрхийн зарим асуудал</i></li> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл, <i>“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдал</i></li> <li>- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дахь илтгэл, <i>“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2019 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдал.</i></li> </ul> <p>2. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2008 оны 8-р сарын 8-ны өдрийн 28 дугаар тушаалаар “Хүний эрх” сэтгүүлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэж байна. Энэ хугацаанд “Хүний эрх” сэтгүүл олон улс, бүс нутгийн болон үндэсний хэмжээн дэх хүний эрхийн бодлого, баримт бичгүүдийг олон нийтэд хүргэх, Монгол Улсад хүний эрхийг төлөвшүүлэх, хүний эрхийн боловсролыг нэмэгдүүлэх, хүний эрхийн онолын судалгааг хөгжүүлэх, тулгамдсан асуудлууд, түүнийг шийдвэрлэх боломж, арга зам, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар эрдэмтэн, судлаачид, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудын бичсэн онол, практикийн өгүүлэл, нийтлэл, танилцуулга, сурталчилгааны материалуудыг олон нийтэд түгээхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ирсэн байна. 2008-2020 хүртэлх хугацаанд Хүний эрх сэтгүүлийн 19 дугаарыг бэлтгэн гаргасан байна.</p> <p>Хүний эрх сэтгүүлийг олон улсын сэтгүүлийн ISSN буюу олон хувь цувралаар хэвлэгддэг хэвлэлд өгдөг Олон улсын стандарт ISSN: 2617-9288 (цахим), <b>ISSN: 2617-927X</b> (хэвлэмэл) дугаартай болсон бөгөөд үүний үр дүнд дэлхийн аль ч орны номын сангаас Хүний эрх сэтгүүлийг үзэх боломжтой болсон юм.</p> <p>3. Хүний эрхийн сургалт</p>
--	---

		<p>Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь хэсэгт зааснаар хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх чиг үүргийнхээ хүрээнд хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох, эрхийнхээ төлөө тэмцэх чадварыг бий болгох зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдэд чиглэсэн олон төрлийн сургалт явуулдаг. Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтэст ажиллах хугацаандаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдэд чиглэсэн 112 удаагийн сургалтад 6809 хүнийг хамруулсан сургалтад оролцож, Хүний эрхэд суурилсан хандлага, Хүүхдийн эрх, хамгаалал, Хүүхдийн эрхийн тухай конвенц түүний нэмэлт протокол, Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах нь хүүхдийн эрх хамгаалал, Жендэрийн эрх тэгш байдал, Хүний эрхийн олон улсын гэрээ, ИБУТЭТП түүний ач холбогдол, Эрүү шүүлтээс ангид байх эрх, Төрийн үйлчилгээ ба хүний эрх, Хүний эрхийн олон улсын гэрээн дэх гэрч, хохирогчийг хамгааллын асуудал зэрэг 12 сэдвээр хичээл заасан. Үүнээс Монголын Хуульчдын Холбооноос баталсан “Хүний эрхийн олон улсын гэрээ”, “Хүүхдийн эрх” сэдвээр Монголын Өмгөөлөгчдийн Холбооны өмгөөлөгч нарт үргэлжилсэн цагийн 5 удаагийн сургалтад хичээл заасан. Комиссын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу болон байгууллага, хамт олны хүсэлт, хамтран ажиллах саналд үндэслэн Монголын Үйлдвэрчний Эвлэл, Монголын бичил уурхай нэгдсэн дээвэр холбооны гишүүд, Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Зэвсэгт хүчний жанжин штабын алба хаагчдыг “Хүний эрхийн сургагч багш”-аар бэлтгэх анхан болон давтан сургалтуудад сургагч багшаар ажиллахаас гадна, сургагч багшийн сургалтыг зохион байгуулах, тухайн салбарын онцлогт тохирсон хүний эрхийн сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсруулах, сургалтын гарын авлага, материалын агуулгыг боловсруулан хэвлүүлэх ажлуудыг хариуцан амжилттай зохион байгуулж ажилласан.</p> <p>4. Хүний эрхийн цуврал лекц</p> <p>Хүний эрхийн Үндэсний Комисс нь Нээлттэй нийгэм форумтай хамтран Монгол Улсад хүний эрхийн онолын ойлголтыг хөгжүүлэх, энэ чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг судлаачдын эрдэм шинжилгээний ажил, хүний эрхийг хамгаалагчдын практик ажлын үр дүнг олон нийтэд хүргэх, нийгэмд тулгамдаад байгаа хүний эрхийн асуудлуудаар хэлэлцүүлэг өрнүүлэх үүднээс хүний эрхийн цуврал лекцийг 2012 оноос эхлэн зохион байгуулж байна. Энэхүү олон нийтийн лекцийн анхны дугаараас эхлэн 2016 оныг дуусталх хугацаанд 32 удаагийн Хүний эрхийн цуврал лекцийн зохион байгуулалттай холбоотой бүхий л үйл ажиллагааг дагнан хариуцаж ажиллахын зэрэгцээ, зарим лекцийг удирдан чиглүүлж явуулсан. Хүний эрхийн лекцийн үр нөлөөг дээшлүүлэх, иргэд олон нийтэд хүртээмжтэй байдлаар түгээн дэлгэрүүлэх талаар санаачлагатай ажиллаж, Нээлттэй нийгэм форумын ажилтнуудтай хамтран лекцийг сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх үүднээс давхар дохионы хэлний хөврүүлэгтэйгээр, видео хэлбэрээр нийгмийн сүлжээний (youtube) хуудас болон цахим хуудаст байршуулсан нь иргэд, олон нийтийн хүний эрхийн боловсролд оруулсан чухал хувь нэмэр болж байна.</p>
--	--	--

		<p>Хүний эрхийн цахим номын сан.</p> <p>Хүний эрхийн Үндэсний Комисс 2004 оноос дэргэдээ 11 мянга орчим англи, орос, герман зэрэг хэл дээр хэвлэгдсэн ном бүхий хүний эрхийн чиглэлээр дагнасан номын сантай болсон. Энэхүү номын сан төсөв хөрөнгө, байр танхимын хүрэлцээгүй байдлаас олон нийтэд нээлттэй үйлчилж чадахгүй, зөвхөн энэ чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж буй хүмүүст гэрээр ном өгөх, Комиссын ажилтнуудын албан хэрэгцээнд шаардлагатай ном, товхимол мэдээллээр үйлчлэх, Комиссоос боловсруулан гаргасан ном товхимолыг хүссэн иргэн, их дээд сургуулийн багш оюутнуудад үнэ төлбөргүй тараах явдлаар үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байсан. Иймээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан цагаасаа хойш хүний эрхийн асуудлаар эрхлэн гаргасан бүх ном товхимолыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим номын санг бий болгох ажлыг санаачлан, удирдан зохион байгуулснаар хүний эрхийн талаарх ном, товхимол, гарын авлага материалыг хүссэн хүн бүр цаг хугацаа алдалгүй шууд үзэж судлах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Мөн ард иргэдийнхээ хүний эрхийн боловсролд хамаарах бүх төрлийн мэдээллийг олны хүртээл болгох, түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах, хамтран ажиллах нэг байгууллага бол нийтийн номын сан хэмээн үзэж, хүний эрхэд ээлтэй номын сангийн үйлчилгээг бий болгож, хөгжүүлэх, харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах нөөц боломжийг бүрдүүлэх үүднээс 2016 оны 12-р сарын 10-ны өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй нийтийн болон эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн номын сантай хамтран ажиллах уулзалтыг санаачлан зохион байгуулж, улмаар Комиссоос эрхлэн гаргасан ном товхимол, гарын авлага материалыг тогтмол хүргүүлдэг болсон.</p> <p>5. Хүний эрхийн сурталчилгаа</p> <p>Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсрол, судалгаа хариуцсан ахлах референтээр ажиллах хугацаандаа 2009 оноос хойш Комиссоос эрхлэн гаргасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 9 удаагийн илтгэлийн эцсийн хяналтыг хийж, хянан хэвлүүлсэн. Хүний эрхийн асуудлаар ном товхимол гаргаж, 5 сургалтын гарын авлага, судалгааны тайлан, 5 төрлийн сурталчилгааны постер, 18 төрлийн эвхмэл хуудас зэрэг нийт 35 төрлийн ном хэвлэл, гарын авлага, тараах материалыг боловсруулах, хянан тохиолдуулах, эрхлэн хэвлүүлэх ажлыг хийж гүйцэтгэн нийтийн хүртээл болгосон.</p> <p>6. Хүний эрхийн цуврал нийтлэл</p> <p>Хүний эрхийн Үндэсний Комисс 2012-2015 онд өдөр тутмын “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан”, “Ардчилал”, “Монголын Үнэн” сонины газартай хамтран ажиллаж, “Хүний эрхийн булан” хөтөлж, долоо хоног бүрийн Бямба гарагт иргэдэд хүний эрхийн боловсролд зориулан хүний эрхийн асуудлаар 280 орчим нийтлэл, ярилцлага, мэдээлэл бэлтгэн нийтлүүлсэн юм. Комиссын ажилтнуудын боловсруулсан нийтлэл, мэдээллийн найруулга, хяналтыг хийж, хэвлүүлэх ажлыг 4 жилийн турш хариуцан гүйцэтгэсэн бөгөөд</p>
--	--	---

		<p>дээрх нийтлэлийг “Хүний эрхийн нийтлэл 2012-2015” цуврал 4 ном болгон эмхэтгэн хэвлүүлж олон нийтийн хүртээл болгосон. Өдөр тутмын зарим сонинд “Хүний эрхийн булан” хөтөлж, долоо хоног бүр хүний эрхийн асуудлаар нийтлэл, ярилцлага, мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэсэн байна.</p> <p>Мөн боловсролын салбарт ажиллагсад, багш, сурган хүмүүжүүлэгч нарын хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, боловсролын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2017 онд “Нээлттэй сургууль” сонинтой хамтран ажиллаж, тус сонины сар бүрийн дугаарт Хүний эрхийн боловсролын талаар 12 цуврал мэдээллийг бэлтгэн хэвлүүлсэн.</p> <p>7. <b>“Хүний эрхийн Үндэсний байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах нь” төсөл</b></p> <p>Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Ази, Номхон далайн чуулганаас Хүний эрхийн сургагч багш нарын сүлжээг бий болгох, сүлжээний гишүүдийг чадавхижуулах төслийг 2017-2020 онд хэрэгжүүлсэн. Энэ төслийн хүрээнд Хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдэн сүлжээний гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд “Хүний эрхийн Үндэсний байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах нь”, “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал мониторинг хийх нь” гэх хоёр бичил төсөл боловсруулж Ази, номхон далайн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган болон Данийн хүний эрхийн хүрээлэнд хүргүүлсэн. Үүнээс “Хүний эрхийн Үндэсний байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах нь” бичил төсөл шалгарч, 500 Австрали долларын тэтгэлэг авсан. 2018 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутгийн ажилтнуудад “Насанд хүрэгчдэд чиглэсэн хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах нь” сэдвээр 2 долоо хоногийн цахим сургалт, төвийн болон орон нутгийн ажилтнуудад 1 өдрийн нүүр тулсан сургалтыг хийсэн.</p> <p>8. “Хүний эрхэд суурилсан хандлага ба жендэрийн тэгш байдлыг хангах чадавхийг бэхжүүлэх, Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээг сайжруулах нь” төсөл.</p> <p>Бичил уурхай эрхлэгчид болон бичил уурхайд хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд хүний эрхийн талаар мэдлэг ойлголт өгөх, эрхээ мэдэх шаардах чадавхитай болгох, төрийн албан хаагчдын хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчдад хүргэх төрийн үйлчилгээг хүний эрхэд ээлтэй болгох зорилгоор Швейцарын Хөгжлийн Агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн нэг бүрэлдэхүүн болох “Хүний эрхэд суурилсан хандлага ба жендэрийн тэгш байдлыг хангах чадавхыг бэхжүүлэх, Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээг сайжруулах нь” төслийг 2015-2018 онд хэрэгжүүлсэн. Миний бие 2006 оноос тус төслийн үйл ажиллагааг Комиссын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийн тайлан мэдээллийг гаргах, үр дүнг үнэлж дүгнэх зэрэг үйл ажиллагааг хариуцан Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран ажилласан.</p> <p>Төслийн хүрээнд Комиссоос Нэгдсэн Үндэстний байгууллагын 2015 оны Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлгээс Монгол Улсын Засгийн Газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, бичил уурхайчдад хүний эрхэд</p>
--	--	--

		<p>суурилсан, жендерийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээ хүргэх үүрэг хүлээгч байгууллага, албан хаагчид болон бичил уурхайчид эрхээ мэдэх, шаардах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгээ нөлөөллийн үйл ажиллагаа явуулж үр дүнд бичил уурхай дахь хүний эрхийн нөхцөл байдал сайжирсан юм. Тухайлбал, хүний эрхийн цахим сургалтын кампусыг бий болгож, хүссэн хүн бүхэн зайнаас суралцах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ, хүний эрхийн чиглэлээрх ном товхимол, гарын авлага, материалыг цахим хэрэгсэл ашиглан уншиж ашиглах, хүний эрхийн зөрчил маргааны талаарх гомдлоо гар утасны аппликэйшнээр дамжуулан хүссэн газраасаа шууд гаргаж шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлсэн олон бодитой ажлыг дурдаж болох юм.</p> <p>9. Олон улсын хурал, чуулган, сургалт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, Ази, Номхон далайн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулган, Швейцарын Хөгжлийн Агентлаг, Азийн форум Солонгосын хүүхдийн эрхийн зөвлөл, Монгол Улсын Хүүхдийн төлөө газар зэрэг байгууллагуудаас Монгол Улсад зохион байгуулсан олон улсын хурал, чуулган, олон улсын сургалтуудыг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, олон улсын хурал, чуулганы зохион байгуулалт, чуулга уулзалтаас гарсан санал зөвлөмжийн төслийг боловсруулах зэргээр дараах арга хэмжээнд хувь нэмрээ оруулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2012 оны 10 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” Олон улсын бага хурал</li> <li>• 2014 оны 8 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Азийн хүүхдийн эрхийн III чуулга уулзалт”</li> <li>• 2015 оны 8 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганы (АНДЧ) ээлжит XX хурал болон хоёр жил тутмын Бага хурал, “Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэхэд хүний эрхийн үндэсний байгууллагын гүйцэтгэх үүрэг” уулзалт</li> </ul> <p>Мөн 2019 оны 8 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Ази, Номхон далайн үндэсний байгууллагуудын Хүний эрхийн мэдээлэл, харилцааны сүлжээний гишүүдэд зориулсан сургалтад туслах багш, чиглүүлэгчээр ажилласан болно.</p>
12	<p><b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар</b> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч,</p>	

	<p>өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолт;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл</li> </ul> <p><b>Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</b></p>	
13	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b></p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</li> <li>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.</li> </ul>	<p>Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч, сургагч багш</p> <p>Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэ, өвчинтэй тэмцэх Үндэсний зохицуулах зөвлөлийн гишүүн, Ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх хорооны дарга. Тус зөвлөлд Хүний эрхийн Үндэсний Комиссыг төлөөлөн 2017 оны 2 дугаар сарын 03-ны өдрөөс хойш ажиллаж байна.</p> <p>Ази Номхон далайн хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Хүний эрхийн сургагч багш нарын сүлжээний гишүүн, сургагч багш</p>
14	<p><b>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</li> <li>-Өөрийн харьяалагддаг</li> </ul>	<p><b>Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж</b></p> <p><i>Хүний эрх сэтгүүл:</i> Хүний эрх сэтгүүлийн 2008/4; 2009/1; 2009/2; 2009/3; 2009/4; 2010/1; 2010/2; 2012/1-2019/2 хүртэлх нийт 23 дугаарыг эрхлэн гаргасан</p> <p><i>Олон улсын хурлын илтгэлийн эмхэтгэл:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Уул уурхайн бизнес ба Хүний эрх” олон улсын бага хурал</li> </ul>



<p>байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• “Азийн хүүхдийн эрхийн гуравдугаар чуулга уулзалт”</li> </ul> <p><i>Хүний эрхийн чиглэлээр боловсруулсан, эмхэтгэсэн, хянасан ном:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Нийгмийн хэв журам ба хүний эрх” илтгэлийн эмхэтгэл</li> <li>• Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжүүдийн эмхэтгэл (1977-2014 он)</li> <li>• Хүний эрхийн цуврал нийтлэл (<i>4 цуврал</i>)</li> <li>• Хүний эрхэд суурилсан Бичил уурхай</li> <li>• Хүний эрхийн билл</li> <li>• “Хүний эрхийн төлөө зүтгэсэн 15 жил” зурагт альбом</li> <li>• Хүний эрхийн эмхэтгэл</li> </ul> <p><i>Сургалтын гарын авлага:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүний эрхийн боловсрол</li> <li>• Хүний эрхэд суурилсан хандлага</li> <li>• Хууль сахиулагч ба хүний эрх</li> <li>• Хорих байгууллага ба хүний эрх</li> <li>• Зэвсэгт хүчин ба хүний эрх (<i>Гарын авлагын 1 бүлгийг орчуулж, бусад бүлгийг хянан тохиолдуулсан</i>)</li> </ul> <p><i>Өөрийн бичиж хэвлүүлсэн ном, өгүүлэл:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Хөдөлмөрлөх эрхтэй холбоотой гомдлууд, тэдгээрт хийсэн шинжилгээ” сэдэвт хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2016.</li> <li>• “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ ба хүний эрх” Хүний эрх сэтгүүл. УБ., 2012, №1</li> </ul> <p><i>Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн:</i></p> <p><i>Хамтран ажиллагсдын хамт бэлтгэсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн зарим бүлэг</i></p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл 2 дугаар бүлэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт</p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл 4 дүгээр бүлэг. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн нөхцөл байдал. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ ба хүний эрх</p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл 3 дугаар бүлэг. Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрхийн нөхцөл байдал</p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл 4 дүгээр бүлэг. Хөдөлмөрийн харилцаан дахь жөндөрийн тэгш</p>
--	--

	<p>байдлын зарим асуудал</p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл 1 дүгээр бүлэг. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал.</p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл 2 дугаар бүлэг. Нийслэлийн хот төлөвлөлттэй холбоотой хүний эрхийн зарим асуудал</p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдал</p> <p>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дахь илтгэл “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2019 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдал</p> <p><i>Нийтлэл:</i></p> <p>“Гэрч, хохирогч хамгаалал” Зууны мэдээ сонин 2012.03.24 №169/72(4071)</p> <p>“Ахмад настны эрх” Зууны мэдээ сонин 2012.09.07 №191/208 (4210)</p> <p>“Нийгмийн халамж хүртэх эрх” Үндэсний шуудан сонин 2013.10.11 №233(1872)</p> <p>Хүний эрхийн сурталчилгаа түүний ач холбогдол Зууны мэдээ сонины 2014.07.04 №154 (4781), Үндэсний шуудан сонины 2014.07.04 №150(2086)</p> <p>Ахмад настнууд ба хөгжил Зууны мэдээ сонины 2014.10.03 №237 (4864)</p> <p>Үндэсний шуудан сонины 2014.10.03 №189 (2125)</p> <p>Хүний эрхийн боловсролд номын сангийн гүйцэтгэх үүрэг Зууны мэдээ сонины 2015.03.13 №51 (4977) Үндэсний шуудан сонины 2015.03.16 №048 (2233)</p> <p>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг хянах НҮБ-ын механизм Зууны мэдээ сонины 2015.09.04 №178 (5104)</p> <p>Хүний эрхийн сургалтын хэрэгцээ, шаардлага, аргачлал Зууны мэдээ сонины 2015.12.21 №253, 254 (5199, 5180)</p> <p><b>Лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ.</b></p> <p><i>Илтгэл</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улс дахь цагаачдад тулгарч буй Хүний эрхийн зөрчлүүд ба өнөөгийн байдал цаашдын хандлага”. Ц.Адъяахишиг Ахлах референт “Олон соёлт нийгэм ба цагаач ажилчдын эрх”. Олон улсын бага хурал. 2009.10.23</li> <li>• “Ажлын байрны бэлгийн дарамтын өнөөгийн нөхцөл байдал”. Ц.Адъяахишиг Ахлах референт “Ажлын байр дарамтгүй орчин” хэлэлцүүлэг. Төрийн ордон, 2019.11.19</li> </ul>
--	--

		<p>Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан ярилцлага, нэвтрүүлэг (сүүлийн 3 жилийн байдлаар)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол TVHD “Оргил цаг” нэвтрүүлэг Зочны цаг Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар  2017 оны 4 дүгээр сарын 18-ний өдөр</li> <li>• Монгол TVHD “Нүүдэл шийдэл” шууд нэвтрүүлэг Хүүхдийн хүмүүжил  2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр <a href="https://www.youtube.com/watch?v=L1Q6Ao7jfew">https://www.youtube.com/watch?v=L1Q6Ao7jfew</a></li> <li>• <b>www.gogo.mn</b> цахим хуудас <b>Хүүхэд зодуулсан гэдгээ л ҮҮРД санана</b>  2017 оны 5 дугаар сарын 30-ны өдөр <a href="https://gogo.mn/r/nx6m2">https://gogo.mn/r/nx6m2</a></li> <li>• МҮОНТВ-ын “Нээлттэй хором” шууд нэвтрүүлэг “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” хэлэлцүүлэг  2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр <a href="https://www.facebook.com/MNBnationalTV/videos/261830881107320/">https://www.facebook.com/MNBnationalTV/videos/261830881107320/</a></li> <li>• МҮОНТВ-ын “Нээлттэй хором” шууд нэвтрүүлэг “Нинжа юу? Бичил уурхай юу?” хэлэлцүүлэг  2018 оны 10 дугаар сарын 03-ны өдөр <a href="https://www.facebook.com/MNBnationalTV/videos/145153569769793/">https://www.facebook.com/MNBnationalTV/videos/145153569769793/</a></li> <li>• Засгийн газрын мэдээ сонин Засгийн газрын мэдээ сонин 2019.11.20 №204(1256)</li> <li>• Livetv.mn <b>Сүүлийн 4 жилийн хугацаанд ажлын байрны дарамтын 11 гомдол л ирсэн</b>  <b>2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр</b></li> </ul>
--	--	---